



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ²² он ⁰⁸ дугаар
сарын ²⁶-ны өдөр

Дугаар ХТТ/1913

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт: ³ хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Засгийн газрын IX байр, Энхтайаны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2022.08.12

№ 01/2511

танай 2022.08.03 -ны № ХЭТ/1781 -Т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Дархан арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар ирүүлсэн асуулгын хариуг хүргүүлж байна.

1. "Дархан арьс ширний цогцолбор" ОНӨХХК-ийн хэрэгжүүлж буй Дархан арьс ширний цогцолбор төслийн үйл ажиллагаа ямар шалтгаанаар зогсонги байдалд орсон талаар:

"Дархан арьс ширний цогцолбор" ХХК нь жилд 10 сая ширхэг хүртэлх арьс шир боловсруулах, ноос, ноолуур угаах самнах нийт 13 үйлдвэр, дэд бүтцийн хамт барьж байгуулах зорилготой хувьцаа эзэмшигч нь Лидер капитал ХХК-ийн 85 хувийн, Дархан-Уул аймгийн ИТХ-ын 15 хувийн хувь оролцоотой компанийг 2018 онд байгуулсан байна. Тус компанийн төслийн ТЭЗҮ-д нийт 586.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байхаар тусгасан байна.

Тус төслийн хүрээнд цахилгааны дэд станц, гадна шугам сүлжээ, бохир ус цэвэрлэх байгууламжийн суурийн ажил, ноос угаах, самнах нэг үйлдвэрийн барилгын суурийн ажлыг эхлүүлсэн байгаа боловч санхүүгийн эх үүсвэр дутагдалтайгаас төслийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон байна.

"Дархан арьс ширний цогцолбор" ХХК нь дээрх дутуу гүйцэтгэлтэй дэд бүтцийн ажлыг төрийн мэдэлд шилжүүлэн улмаар төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн дуусгуулах саналыг тавьсан ба Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас Үндэсний аудитын газарт дэд бүтцийн ажлын гүйцэтгэлд аудит хийж өгөх хүсэлт тавьсны дагуу Үндэсний аудитын газраас 2021 онд Дархан арьс ширний цогцолбор төслийн хүрээнд зээлийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын гүйцэтгэлд төлөвлөгөөт бус аудит хийж, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/127 дугаар тушаалаар аудитын тайланг баталгаажуулан ирүүлсэн. Тус тайланд Өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний дагуу олгогдсон санхүүжилтээс арьс ширний үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжид 7,131.7 сая төгрөг, цахилгаан түгээх, хангах дэд станцад 2,905.0 сая төгрөг, гадна инженерийн шугам сүлжээний дулааны шугам, цэвэр усан хангамжид 2,650.0 сая төгрөг, технологийн уур үүсгэгчийн барилга байгууламжид 40.7 сая төгрөг нийт 12.727.4 сая төгрөгийг зарцуулсан. Санхүүгийн түрээсээр

70001141

цахилгаан түгээх, хангах дэд станцыг байгуулахад 3,282.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн. Тус цогцолборын бүтээн байгуулалтад дэд бүтцийн 5 багц ажлын дундаж гүйцэтгэл 50.7 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэлд Монгол Улсын Хөгжлийн банкны Өрийн бичгийн 12,727.4 сая төгрөг, Санхүүгийн түрээсийн 3,282.3 сая төгрөг, Энгийн хувьцаагаар 8,193.3 сая төгрөг, хувийн хэвшлийн 16,661.9 сая төгрөг нийт 40,864.9 сая төгрөг зарцуулсан гэж үндэсний аудитын газрын дүгнэлтээр гарсан байна.

Мөн манай яамны зүгээс Эрчим хүч, дэд бүтцийн ажлыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргуулахаар Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн ч одоогоор шинжээчийн дүгнэлт эцэслэж ирээгүй байгаа болно.

"Дархан арьс ширний цогцолбор" ХХК нь Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн нийт 18.7 тэрбум төгрөгийн зээлийн барьцаанд ирээдүйд орох орлого, эзэмшлийн 180 га газар, тус төслийн хүрээнд бий болох дэд бүтцийг Хөгжлийн банканд барьцаалсан байгаа тул энэхүү барьцаалсан дэд бүтцийг хэрхэн шийдвэрлүүлэх талаар одоогоор Хөгжлийн банкнаас санал ирээгүй байна.

2. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан "Дархан арьс ширний цогцолбор" ОНӨХХК-ийн хэрэгжүүлэх "Арьс ширний цогцолбор" байгуулах төслийн талаар Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь "Дархан арьс ширний цогцолбор" ХХК-тай 2020 оны 5 дугаар сарын 15-нд "Бодлогын гэрээ"-г байгуулж, тус гэрээгээр банк, санхүүгийн байгууллагаас санхүүжих зээлийн хүүгийн хөнгөлөлтийг банк, аж ахуйн нэгж, яам хамтран "Зээлийн хүүгийн татаас олгох гэрээ"-г байгуулсны үндсэн дээр хүүгийн дэмжлэг үзүүлж ажиллахаар заасан. 2020 онд хүүгийн дэмжлэг олгох гэрээ байгуулах саналыг "Ди Би Эм лизинг" ХХК, "Ди Би Эм Ассет менежмент ҮЦК" ХХК болон Дархан арьс ширний цогцолбор ХХК-уудаас "Дархан арьс ширний цогцолбор байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн эх үүсвэрт зээлийн хүүгийн татаас олгох гэрээний санал" ирүүлсний дагуу "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн 54 дүгээр тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу дахин хэлэлцэхээр хойшлуулан шийдвэрлэсэн. Мөн 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтад зориулан 10.0 тэрбум төгрөгийг батлуулсан боловч Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооноос "Дархан арьс ширний цогцолбор" ХХК-ийн дэд бүтцийн ажлын магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй, өмчлөгч тодорхой бус, тендер зарлах байршил зөрүүтэй, баригдсан бүтээн байгуулалтын ажил нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулалт хийгдээгүй гэх шалтгаанаар тендер зарлах боломжгүй гэж үзсэн байна.

Засгийн газраас хувийн хэвшлийн гүйцэтгэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж ажилласан боловч тус компани хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалд орж төслийн ажил удааширсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1-д Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг


сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд Дархан арьс ширний цогцолборыг байгуулахаар тусгагдсан; Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.10-д “Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүн экспортыг нэмэгдүүлнэ...”; Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.3.10.1-д “Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн 100 хувийн өмчит ХХК-ийг байгуулан бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. Монгол Улсын Засгийн газраас арьс, шир боловсруулах цогцолбор үйлдвэрийн бүтээн байгуулалтад онцгой анхаарал хандуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дэлхийд тэргүүлэгч байгууллагатай хамтран ажиллах, дэлхийн болон Европын Холбооны стандартад нийцсэн сүүлийн үеийн технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлсэн Дарханы арьс ширний цогцолборыг байгуулах ажлыг эхлүүлээд байна. Өнөөдрийн байдлаар цогцолборын техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дууссан ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийж байгаа бөгөөд, төслийн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, үйлдвэрлэлийн технологийн зураглалыг Италийн Имагро, Италипрожетти компаниудтай хамтран гүйцэтгээд байна.

Тус төслийн хүрээнд жилдээ 400 мянган бодын шир боловсруулах 1 үйлдвэр, 4 сая ширхэг богийн арьс, шир боловсруулах 4 үйлдвэр байгуулагдаж, нийтдээ үйлдвэрт 700 гаруй, дагалдах 1500 орчим ажлын байр бий болно. Төсөл хэрэгжсэнээр уул уурхайн бус экспортын орлого жилд дунджаар 85 сая доллароор өсөж, малчдын амьжиргааг жилд 68 тэрбум төгрөгөөр дэмжиж, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 250 тэрбум төгрөгөөр, ДНБ-ийг жилд дунджаар 126 тэрбум төгрөгөөр, Дархан хотын ДНБ-ийг 17%-иар өсгөх урьдчилсан тооцоо гараад байна.

3. Засгийн газрын 2020 оны 234 дүгээр тогтоолоор "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХХК болон "Дархан арьс ширний цогцолбор" ОНӨХХК-ийн хамтын ажиллагаа буюу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар:

“Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК нь “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-тай хамтран ажиллах чиглэлд харилцан мэдээлэл солилцож, дэд бүтцийг ашиглах, тус компанийн эзэмшлийн талбайд 5 үйлдвэр барих саналыг гаргасан боловч газар, дэд бүтэц нь Хөгжлийн банкны барьцаанд байгаа тул шийдвэрлэгдээгүй. Монгол Улсын Хөгжлийн банк, “Дархан арьс ширний цогцолбор” ХХК хамтран дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг шийдвэрлэсний дараа хамтран ажиллахад бэлэн байгаа болно.

Хүндэтгэсэн,

A red rectangular official stamp from the Ministry of Industry and Trade of Mongolia. The stamp contains the text "МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК" (Mongolian Development Bank) and "ХӨГЖИЛ, АЖ АХУЙН ГАРЛАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БӨЛӨВСРҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР" (Program for the development of the leather and fur industry). A handwritten signature in black ink is written over the stamp.

З.МӨНДСАЙХАН